



УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

□ "ДАНШИГ НААДАМ-ХҮРЭЭ ЦАМ-2024" □  
наадмын үзэсгэлэн зохион байгуулах  
ажлын төлөвлөгөө, зардлын төсөв,  
ажиллах хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/850 дугаар захирамж, Музейн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголчуудын өв соёл "ДАНШИГ НААДАМ-ХҮРЭЭ ЦАМ-2024" наадмын үзэсгэлэн гаргах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар, ажиллах хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үзэсгэлэнгийн зардлыг бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас гаргахыг ахлах нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.
3. Амралтын өдрүүдэд ажилласан албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу илүү цагийн хөлсийг тооцож олгохыг ахлах нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.
4. Төлөвлөгөөт арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг менежер (Б.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  П.ДАВААСҮРЭН



Музейн захирлын 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/32 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

9097104 СТА3737 9022031489

Зорилго: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/850 дугаар захирамжийн хүрээнд "Даншиг наадам-Хүрээ цам 2024" наадмаар "БОГДЫН ХҮРЭЭ БА УЛААНБААТАР" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулахад оршино.

**"БОГДЫН ХҮРЭЭ БА УЛААНБААТАР"- ҮЗЭСГЭЛЭНГИЙН  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх ажил	Хариуцах мэргэжилтэн	Хугацаа	Анхаарах зүйлс
1.	Төсөв гаргах	Б.Нарангэрэл	07/29	Шаардлагатай төсөв гаргаж удирдлагад санал оруулах
2.	Батлагдсан төсвийн дагуу нэмэлт санхүүжилтийн зардлын эрхийг зохих эдийн засгийн ангилалаар нээлгэж, олгох	Ж.Мөнхтуяа	07/31	Холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтыг бүрдүүлж, санхүү төрийн сангийн хэлтсээр хянуулж, санхүүжилтийн эрхийг нээлгэх
3.	Үзэсгэлэнгийн төлөвлөгөө боловсруулан батлуулах	Б.Нарангэрэл Б.Өлзийбаяр	07/30	Үзэсгэлэн зохион байгуулахад ажилтнуудын хийх ажлыг хуваарилах
4.	Үзэсгэлэнд тавигдах гэрэл зургийн судалгаа хийж, сонгох	Г.Очбаяр О.Одсүрэн	07/29	Сонгогдсон гэрэл зургуудын хэвлэлт, жаазлах зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих
5.	Сонгогдсон гэрэл зургуудыг үзэсгэлэнд бэлтэх тухай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	Б.Нарангэрэл	07/29	Гэрээний дагуу ажлаа цаг хугацаанд нь гүйцэтгэж буйд хяналт тавих
6.	Гэрэл зургийн тайлбар бэлтгэх (Монгол, Англи)	Г.Очбаяр О.Одсүрэн С.Эрдэнэбат Б.Өлзийбаяр	07/29	Тайлбарыг судалгааны үндсэн дээр бичиж музейн хаяг тайлбар бичих журмын дагуу бэлтэн хэвлэх
7.	Үзэсгэлэнгийн асарт үзэсгэлэнг дэглэх	О.Одсүрэн Ж.Хадбаатар С.Эрдэнэбат Ч.Хишигдэлгэр	08/03	Үзэсгэлэнг үзэгчдэд хүртээмжтэй байдлаар дэглэх, үзмэртэй анхаарал болгоомжтой харьцах
8.	Үзэсгэлэнгийн товч танилцуулга бүхий хэвлэмэл самбарын эх бэлтгэн хэвлүүлэх	С.Эрдэнэбат	07/30	Хэвлэмэл самбарын үзэсгэлэнгийн асарт байрлуулах

9.	Үзэсгэлэнгийн тухай музейн цахим сайт болон бусад сайтад мэдээлэл байршуулах	Л.Одмаа С.Эрдэнэбат	08/03,04	Үйл ажиллагааны зураг тайлбарийг сайтад байршуулан хандалтын тоог өсгөх
10.	Үзэгчдийг хүлээн авч үзэсгэлэнгийн дэлгэрэнгүй тайлбараар үйлчлэх, үзэгчийн тойм тоон дүнг гаргах	Тухайн өдөр ажилласан ажилтнууд	08/03,04	Үзэсгэлэнгийн үйл ажиллагааны гэрэл зургийг тогтмол авах
11.	Үзэсгэлэнг буулган музейд авчрах	Тухайн өдөр ажилласан ажилтнууд	08/04	Гэрэл зургуудыг аюулгүй байдлыг ханган тээвэрлэх
12.	Үзэсгэлэнгийн тайлан бичих	Б.Өлзийбаяр	08/05	Үзэсгэлэнгийн гэрэл зураг, тоон дүнг нэгтгэн хугацаанд нь хариуцсан дээд байгууллагад тайланг илгээх

### Гэрэл зургийн сонголт

№	Нэр, төрөл	Гэрэл зургийн тоо ширхэг
<b>Нэг. Богдын хүрээ хот</b>		
1	Хүрээ цам	3
2	Даншиг наадам	3
3	Хүрээний хүн ам – Антропологи	3
4	Хүрээний сүм хийд, барилга	2
5	Хүрээний гудамж	3
6	Хүрээний ерөнхий дүр төрх	3
Нийт:		17
<b>Хоёр. Социалист Улаанбаатар</b>		
7	Социалист Улаанбаатар хотын ерөнхий дүр төрх	5
8	Үйл явдал	2
9	Гудамж	3
1	Хүмүүс	2
1	Бүтээн байгуулалт	3
Нийт:		15
<b>Гурав. 1990 оны дараах Улаанбаатар</b>		
1	Хотын ерөнхий дүр төрх	3
1	Хотын төвийн хэсгийн ерөнхий байдал	1
1	Хүмүүс	1
1	Бүтээн байгуулалт	1
1	Шөнийн Улаанбаатар	1
1	Онцлох зураг	1
Нийт:		8
<b>БҮГД:</b>		<b>40</b>

Музейн захирлын 2024 оны 07  
дугаар сарын 31 -ны өдрийн А/32  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

9097104 СТА3737 9022031499

"Даншиг наадам-Хүрээ цам 2024" наадмаар "БОГДЫН ХҮРЭЭ БА УЛААНБААТАР"  
сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах зардлын төсөв

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Үзэсгэлэнд тавигдах нягтаршил сайтай гэрэл зураг хальсаар худалдан авах	Ш	40	85,000	3,400,000
2.	Гэрэл зураг томруулж буулгах, угаах зардал Хэмжээ 60x80	Ш	40	96,000	3,840,000
3.	Гэрэл зургийг буулгах хавтан, жааз, хүрээний үнэ	Ш	40	21,000	840,000
4.	Гэрэл зургийг жаазлах, хүрээлэх, наах зардал	Ш	40	10,000	400,000
5.	Гэрэл зургийг тээвэрлэх, ачиж, буулгах зардал	Рейс	2	250,000	500,000
	<b>Нийт дүн</b>				<b>8,980,000</b>

Музейн захирлын 2024 оны 07.  
дугаар сарын 31 -ны өдрийн А/32  
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

9037104 GTA3737 9022031489

"Даншиг наадам-Хүрээ цам 2024" наадмаар "БОГДЫН ХҮРЭЭ БА УЛААНБААТАР"  
сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнд ажиллах хуваарь

2024 оны 5 дугаар сарын 03

Д/д	Ажилтны нэрс	Албан тушаал	2024 .08.03 Бямба	2024.08.04 Ням
1.	О.Одсүрэн	ЭША	8 цаг	
2.	Л.Одмаа	Боловсролын ажилтан	8 цаг	
3.	С.Эрдэнэбат	Дизайнер	8 цаг	
4.	Б.Ариунцэцэг	Үзмэр харгалзагч	8 цаг	
5.	Б.Нарангэрэл	Менежер		8 цаг
6.	Ч.Өсөхжаргал	Бүртгэл мэдээллийн санч		8 цаг
7.	Б.Өлзийбаяр	Арга зүйч		8 цаг
8.	П.Ариунаа	Сан хөмрөгч		8 цаг

Хүй долоон худаг дээр 09:00 цагаас 18:00 хүр

## ХУУЛИЙН ҮНДЭСЛЭЛ

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг  
67.5. Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
  
- Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дэх хэсэг  
109.2. Долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.
  
- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь хэсэг  
16.5.1. төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах  
16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
  
- Музейн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4.5 дахь заалт  
8.4.5. Ажлын онцлогоос шалтгаалан ажилтныг илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулсан бол уг ажилтантай тохиролцсоноор нөхөж амрах, эсхүл нэмэгдэл хөлсийг "Хөдөлмөрийн туай хууль"-д заасны дагуу тооцож олгоно.